



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Заг сумын Эрүүл мэндийн төвийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: БНА-2020/128/СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn

Баянхонгор хот

2020 он

Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга
бөгөөд Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат

Утас: 99007576 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn

Аудитын менежер: А.Цээням

Утас: Утас: 88011833 Цахим хаяг: tseenyma@audit.gov.mn

Аудитор: Г.Ганчимэг

Утас: 88268424 Цахим хаяг: ganaa_7133@yahoo.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

005

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт

Агуулга

Аудитын гэрчилгээ	3
Аудитын тайлан	5
2.1. Оршил.....	5
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	5
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	5
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	6
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	6
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал.....	7
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	7
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	7
2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	8
2.11. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	9
2.12. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	10
2.13. Шилэн дансны мэдээлэл	11
2.14. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт	11
2.15. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	11
Менежментийн захидал	12
1.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан.....	13
4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	14
4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан	16
4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	18
4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	18
4.6 Аудит хийгдсэн нэмэлт санхүүжилтийн тайлан.....	20

Аудитын гэрчилгээ



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

64101 Баянхонгор аймаг,
Баянхонгор сум, Номгон баг
Утас, факс 7044 2584
E-mail: bayankhongor@audit.gov.mn

Г ЗАГ СУМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН
ТӨВИЙН ДАРГА О.ГЭРЭЛЧИМЭГ
ТАНАА

᠑᠐᠒᠐.᠐2.14 № 1/80

танай _____ -ны № _____ -т

Г Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-т заасны дагуу Заг сумын Эрүүл мэндийн төвийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Заг сумын Эрүүл мэндийн төвийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Заг сумын Эрүүл мэндийн төвийн 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэлийн хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

D:\бичиг хэрэг 2020-Албан тоот А4\ 005020032

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-т заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудитын хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.МӨНХБАТ

D:\бичиг хэрэг 2020-Албан тоот А4\

Аудитын тайлан

2.1. Оршил

Заг сумын Эрүүл мэндийн төвийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг дарга О.Гэрэлчимэг танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй, болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Заг сумын Эрүүл мэндийн төвийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Заг сумын Эрүүл мэндийн төвийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020.02.10-аас 2020.02.13-ний хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020.02.13-ний өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Баянхонгор аймаг дахь төрийн аудитын газрын аудитор Г.Ганчимэг хариуцаж хэрэгжүүлэв.

Заг сумын Эрүүл мэндийн төвийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Баянхонгор аймаг дахь төрийн аудитын газар-т 2020.01.25-ний өдөр, аудит хийлгэх хүсэлтээ 2019.12.24 ний өдрийн 92 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Заг сумын Эрүүл мэндийн төвийн үйл ажиллагааны эрхэм зорилго нь "Сумынхаа хүн амд эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээг тасралтгүй зарчмаар стандартын дагуу чанартай тэгш шударга жигд үзүүлэхэд оршино. гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Заг сумын Эрүүл мэндийн төвийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

Хүн ардынхаа эрүүл мэндийг сайжруулахад үйлчлүүлэгчдээ хамгийн ээлтэй тусламж үзүүлэгч эрүүл мэндийн байгууллагаар үнэлэгдэж итгэл хүлээлгэхийг эрхэмлэнэ.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт ороогүй байна.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Тус газрын одоо мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлого нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Тус газрын санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн төвөгтэй байдлыг үнэлэхэд Шаардлагагүй буюу мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй тул аудитыг шууд гүйцэтгэлээ.

Заг сумын Эрүүл мэндийн төв нь санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн "Санхүүгийн тооцоолох групп" ХХК-ийн "Acolous" программ хангамж ашиглаж байна.

Заг сумын Эрүүл мэндийн төв дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд Дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар Заг сумын Эрүүл мэндийн төвийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 33 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 33 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 393643,1 мянган төгрөгөөс тооцон 7872,8 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг үр дүнгийн тайлангийн нийт зардлын 2% буюу 8136,7 мянган төгрөгөөр тооцсон нь үр дүнгийн тайлангийн зардлыг суурь болгон сонгосонтой холбоотой болно.

2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Заг сумын Эрүүл мэндийн төвийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 7287,2 мянган төгрөгөөр буюу 7,2 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөг/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0	0	0
Авлага	0	414,9	0
Урьдчилгаа	0	0	0
Бараа материал	12140,1	15606,0	3465,9
Үндсэн хөрөнгө	995071,8	998893,1	3821,3

Заг сумын Эрүүл мэндийн төв 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Хуримтлагдсан элэгдэл	-98899,2	-112011,9	-13112,7
Нийт хөрөнгө	908312,7	902902,2	5410,5
Өр төлбөр	0	285,1	-285,1
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	908312,7	902617,0	5695,7
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	908312,7	902902,2	5410,5

Авлага дансны үлдэгдэлд өмнөх оноос 414,9 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээ үзүүлэхэд шаардлагатай шатахууны нөөц бүрдүүлснээс шалтгаалжээ.

Бараа материалын дансны үлдэгдэл өссөн нь төсвийн хөрөнгөөр 3465,9 мянган төгрөгөөр өссөн нь хүнсний нөөц бүрдүүлж, эмийн зардлаас урвалж бодис бэлдсэнээс шалтгаалжээ. Бараа материалын дансны үлдэгдэлд 2015-2019 онд худалдаж авсан 12048,5 мянган төгрөгийн байгууллагын үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа бараа материал байна.

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл өссөн нь төсвийн хөрөнгөөр 4950,0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, 6668,0 мянган төгрөгийн тавилга эд хогшил худалдан авсан, ЭМЯ-ны хөрөнгө оруулалтаар 29700,0 мянган төгрөгийн автомашин үнэ төлбөргүй шилжиж ирснээс шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгийн данснаас АИТХ-ын 2019 оны 10 дугаар сарын 24 ний өдрийн 100 тогтоолоор УАЗ-315195 маркийн 18-66 БНХ дугаартай автомашиныг сумын ИТХ-д балансаас баланст шилжүүлсэн, цаашид албан хэрэгцээнд ашиглах боломжгүй болсон 1955,0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, 41,6 мянган төгрөгийн тавилга эд хогшил, акталж данснаас хассан.

Биет бус хөрөнгийн данс болон хасагдуулга дансанд өөрчлөлт ороогүй байна.

Өр төлбөрийн данс 285,1 мянган төгрөгөөр өссөн нь нягтлан бодогч тооцоог тухай бүр хийж ажиллаагүй улмаас Нийгмийн даатгалын шимтгэлийн өглөг үүссэн байна энэ найдваргүй авлагын үүсэх эрсдэлтэй

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 902617,0 мянган төгрөг болж 5695,6 мянган төгрөгөөр буурсан үзүүлэлт нь тайлант үеийн үр дүнгийн зардлаар буурсан байна.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт, алдааны залруулга гараагүй дахин үнэлгээний дансанд өөрчлөлт ороогүй байна.

2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Заг сумын Эрүүл мэндийн төв нь тайлант онд үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогын төлөвлөгөө батлагдаагүй бөгөөд орлого ороогүй байна.

Тайлант онд Төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх 2 хөтөлбөр, 5 зориулалтад 378558,2 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 378558,2 мянган төгрөгийг урсгал зардалд зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын 317419,3 мянган төгрөгийг улсын төсвөөс 13957,1 мянган төгрөгийг орон нутгийн орлогоос 21163,9 мянган төгрөгийг Эрүүл мэндийн даатгалын сангийн орлогоос санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 369811,7 мянган төгрөг буюу 97,7 хувьтай байгаа нь жирэмсэн амаржсаны чөлөөтэй албан хаагч 2 байгаагаас цалингийн зардлаас 1303,6 мянга, ндш-зардлаас 184,1 мянга тогтмол зардлаас 36,6 буюу улсын төсөвт 1503,0 мянга, орон нутгийн төсөвт 36,6 мянга нийт 1539,6 мянган төгрөгөөр хэмнэж төвлөрүүлсэн бөгөөд эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих хөтөлбөр арга хэмжээг 1,2,3,4 саруудад хэрэгжээгүй улмаас 7206,7 мянган төгрөгийн санхүүжилт олгогдоогүй байна.

Нэмэлт төсөв: Дээд шатны төсөв захирагч буюу аймгийн эрүүл мэндийн газраас сорьц тээвэрлэх тээврийн зардал 89,1 мянга нэмэлтээр санхүүжүүлсэн бөгөөд зардлыг зориулалтын дагуу зарцуулж тайлагнасан байна.

2.11. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 6 чиглэлээр аудитын 33 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 4 асуудлыг алдаа, зөрчилтэйд тооцож, 29 асуудлыг алдаа, зөрчилгүйд тооцлоо.

Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээллийг В30103 маягтаар нэгтгэж, баримтжуулсан болно.

Аудитын явцад илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

Аудитаар нийт 7977,8 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 6797,9 мянган төгрөгийн зөрчилд 2 акт тогтоож, 1179,9 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 2 зөвлөмж өглөө.

Аудитаар дараах залруулагдаагүй алдаа, зөрчил илэрснээс 6797,9 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож хүргүүлээ. Үүнд:

1.Тайлант хугацаанд хэрэгжүүлэх ерөнхий чиглэл

Цалингийн зардлаас цалингийн цэст болон ерөнхий дэвтэр журналаас түүвэрлэн шалгахад Эрүүл мэндийн төвийн даргын 2019 оны 12 дугаар сарын 17 өдрийн 57 тоот тушаалаар цалингийн зардлаас 4600.0 мянган төгрөгийг 23 албан хаагчид түлшний хөнгөлөлтөөр олгож зардлыг зориулалт бусаар зарцуулсан, мөн ЗДТГ-ын нягтлан бодогчоор байгууллагын нягтлан бодогчийн ажлыг түр хавсран гүйцэтгүүлэхдээ албан хаагчдын цалин тогтоолт шинэчлэн батлах 2019 оны 01 дүгээр сарын 05 өдрийн 01 тушаалд нягтлан бодогчийг ТҮ-8-5 дугаар шатлал буюу 738.5 мянган төгрөгийн үндсэн цалингаар цалинжуулах шийдвэр гаргаснаас 697.9 мянган төгрөгийг илүү олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16.5.5 “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Сангийн сайдын 2014 оны 3 дугаар сарын 14 ний өдрийн 55 дугаар тушаалаар баталсан “Төсвийн зарлагын эдийн засгийн ангиллыг ашиглах заавар”, Засгийн газрын 2019 оны 9 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан “Төрийн жинхэнэ албан хаагчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэхэд цалин, урамшуулал олгох журам”-ын 2.2-т “Энэ журмын 2.1-д заасан түр орлон гүйцэтгэх хугацаа нь 6 сараас дээш үргэлжлэх бол түр орлон гүйцэтгэж байгаа албан тушаалын цалингийн 40 хүртэл хувийг түр орлон гүйцэтгэсэн төрийн жинхэнэ албан хаагчид олгоно” 2.4-т “Төрийн албаны тухай хуулийн 3.1.4-т тодорхойлсон сул орон тооны албан үүргийг түр орлон гүйцэтгэх тохиолдолд тухайн албан тушаалын үндсэн цалингийн зөрүүг түр орлон гүйцэтгэсэн хугацаагаар тооцож олгоно. Албан үүргийг түр орлон гүйцэтгэгчийн үндсэн цалин, сул орон тооны албан тушаалын үндсэн цалинтай адил буюу түүнээс бага байх тохиолдолд энэ журмын 2.2-т заасныг баримтална” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн “Үнэн зөв байдал” батламж мэдэгдлийг хангахгүй байна

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоох.

2. Тайлант хугацаанд хэрэгжүүлэх ерөнхий чиглэл

Бараа материалын орлого, зарлага, материалын үлдэгдлийн журналаас тулган хөөн тооллогын бүртгэлтэй тулгахад хоолны зардалд 6900.0 мянга төгрөг батлагдсанаас 6113.4 мянган төгрөгийн гүйцэтгэл гарсан бөгөөд 2137.1 мянган төгрөгийн хүнсний материалын үлдэгдэлтэй бөгөөд үлдэгдлийг түүвэрлэж тулгахад мах, цагаан идээ, чихэртэй ааруул зэрэг хүнсний бүтээгдэхүүнийг төсөвтэй харьцуулахад их хэмжээгээр авч нөөцөлсөн байна. Хоолны зарцуулалтыг сүүлийн 3 сарын дунджаар төсвийг тооцож үзэхэд сард 450.0 мянган төгрөгийн зарцуулалт гарч байгаагаас үзэхэд 4 сарын хүнсний нөөц бэлдсэн байгаа нь хадгалалтын хугацаа алдагдах, чанар байдал өөрчлөлт орох хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдал хангахгүй байх эрсдэлтэй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоох.

Аудитаар илэрсэн 1179,9 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 2 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа.

2.12 Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал
Байхгүй

2.13 Шилэн дансны мэдээлэл

Заг сумын Эрүүл мэндийн төв нь Тухай жилийн төсөвт орсон нэмэлт өөрчлөлт, Хөрөнгийн болон урсгал зардалд тусгагдсан арга хэмжээний төндөрийн ерөнхий мэдээлэл, Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ хугацаанд байршуулсан боловч аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын газраас шилэн дансанд хийсэн шалгалтаар мэдээллийг дутуу, буруу байршуулсан зөрчлийг арилгасны улмаас 1-9 дүгээр саруудад Бонд, зээл өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр 1-5 сард, 5 сая төгрөгөөс дээш үний дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний гүйлгээг 12 сард хугацаа хоцорсон нийт 33 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна. Үүнд:

д/д	Хугацаа	Төрөл	Удаа	Хугацаанд байршуулсан	Хугацаа хоцроож байршуулсан	Байршуул аагүй
1	Бүтэн жил	11	11	11		
2	Хагас жил	4	4	4		
3	Улирал бүр	1	4	4		
4	Сар бүр	3	36	36		
5	Тухай бүр	8	96	63	33	
6	Нийт	27	151	118	33	

2.14 Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар зөвлөмж өгөөгүй байна.

2.15 Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Зөрчилгүй” дүгнэлт

Заг сумын Эрүүл мэндийн төвийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг холбогдох хууль, УСНББОУС, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4.1.3 дахь заалтын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. Тайлант хугацаанд хэрэгжүүлэх ерөнхий чиглэл

1.1. Илрүүлэлт:

Тус байгууллагын программ хангамжийн дансанд 1629.7 мянган төгрөгийн нийт 6 төрлийн биет бус хөрөнгө бүртгэсэн байна. Тухайн хөрөнгийг нэр төрлөөр нь авч үзэхэд 2005 онд "Windows XP, Office 2003, программын лиценз 607.5 мянга, Винница санхүүгийн программ 297.8 мянга, мof программ нэрээр 75.5 мянган төгрөгөөр авсан тухайн программ нь байгаа эсэх тодорхой биш 2010 онд 200.0 мянган төгрөгөөр худалдаж авсан архивын болон дээрх программууд ашиглалтгүй, элэгдлийн хугацаа дууссан 1179.9 мянган төгрөгийн программ байна.

1.2. Эрсдэл:

Ашиглалтгүй биет бус хөрөнгийг нягтлан бүртгэл, тайлангаас хасаагүй байх

1.3. Өгсөн зөвлөмж:

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн дагуу ашиглалтгүй байгаа программ хангаж судалж холбогдох журмын дагуу шийдвэрлэх, зөрчлийг давтан гаргахгүй байх.

1.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

2. Тайлант хугацаанд хэрэгжүүлэх ерөнхий чиглэл

2.1. Илрүүлэлт:

Тухайн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, системтэй танилцахад нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг байгууллагын онцлог, үйл ажиллагааг тусгаж боловсруулсан жишиг бичиг баримт байхгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2 Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана, 20 дугаар зүйлийн 20.2.2.-т “аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулах, батлуулах, хэрэгжилтийг зохион байгуулах” гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.

2.2. Эрсдэл:

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох стандартын шаардлага хангаагүй байх

2.3. Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулж, баталж, мөрдөж ажиллах.

2.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана

3.3 Өгсөн зөвлөмж: НБББББ-ыг боловсруулж ажиллана

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 5 дугаар сарын 01-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	12,140,143.18	16,020,971.18
33	АВЛАГА	00.00	414,900.00
335	Бусад авлага	00.00	414,900.00
3351	Байгууллагаас авах авлага	00.00	414,900.00
35	БАРАА МАТЕРИАЛ	12,140,143.18	15,606,071.18
351	Түүхий эд материал	4,397,428.00	5,208,401.00
35110	Тусгай зориулалттай материал	4,012,200.00	3,788,072.00
35130	Эм боох материал	385,228.00	1,420,329.00
354	Хангамжийн материал	7,742,715.18	10,397,670.18
35410	Бичиг хэргийн материал	78,100.00	137,500.00
35420	Аж ахуйн материал	3,115,330.00	3,321,705.00
35440	Түлш, шатах тослох материал	00.18	00.18
35460	Хүнсний материал	1,131,485.00	2,137,165.00
35470	Бусад хангамжийн материал	3,417,800.00	4,801,300.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	896,172,565.99	886,881,251.25
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	896,172,565.99	886,881,251.25

Заг сумын Эрүүл мэндийн төв 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

392	Биет хөрөнгө	882,606,565.99	873,315,251.25
39201	Барилга, байгууламж, орон сууц	840,805,657.00	840,805,657.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	00.00	-22,323,379.80
39203	Авто-тээврийн хэрэгсэл	40,600,000.00	34,800,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-19,377,085.86	-3,631,375.03
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	92,053,543.84	95,048,483.31
39206	Хуримтлагдсан элэгдэл	-72,661,694.93	-78,872,463.48
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	6,291,896.00	12,918,289.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-5,230,750.06	-5,554,959.75
39217	Ном	125,000.00	125,000.00
393	Биет бус хөрөнгө	13,566,000.00	13,566,000.00
39301	Програм хангамж	1,629,762.00	1,629,762.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-1,629,762.00	-1,629,762.00
39303	Бусад биет бус хөрөнгө	13,566,000.00	13,566,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	908,312,709.17	902,902,222.43
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	00.00	285,198.47
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	00.00	285,198.47
413	Өглөг	00.00	285,198.47
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	00.00	285,198.47
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	908,312,709.17	902,617,023.96
51	Засгийн газрын хувь оролцоо	908,312,709.17	902,617,023.96
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	190,149,470.50	190,149,470.50
51101	Өмч: - төрийн	190,149,470.50	190,149,470.50
512	Хуримтлагдсан үр дүн	138,643,342.61	132,947,657.40
51210	Өмнөх үеийн үр дүн	138,643,342.61	138,643,342.61
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	-5,695,685.21
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	579,519,896.06	579,519,896.06
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	908,312,709.17	902,902,222.43

4.1 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан /төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	322,100,814.00	401,140,580.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	2,790,140.00	29,700,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	2,790,140.00	29,700,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	2,790,140.00	29,700,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	2,790,140.00	29,700,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	33,580,274.00	54,021,280.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	285,730,400.00	317,419,300.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	23,357,442.00	89,100.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	23,357,442.00	89,100.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	00.00	39,975,000.00

Заг сумын Эрүүл мэндийн төв 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	00.00	39,975,000.00
1330	Төсвийн захирагчдаас	7,619,000.00	00.00
133003	Хөрөнгийн	7,619,000.00	00.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	2,603,832.00	13,957,180.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	2,603,832.00	00.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	00.00	13,957,180.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	344,785,178.17	392,109,267.74
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	318,812,825.17	390,569,535.74
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	180,669,867.00	226,592,430.47
210101	Үндсэн цалин	136,799,596.00	226,592,430.47
210102	Нэмэгдэл	31,023,849.00	00.00
210104	Урамшуулал	12,846,422.00	00.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	21,057,742.00	29,268,827.00
210201	Тэтгэврийн даатгал	17,236,756.00	12,088,649.00
210202	Тэтгэмжийн даатгал	977,454.00	3,861,491.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	359,209.00	2,173,059.00
210204	Ажилгүйдлийн даатгал	110,508.00	978,489.00
210205	Эрүүл мэндийн даатгал	2,373,815.00	10,167,139.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	37,426,132.00	36,640,859.00
210301	Гэрэл, цахилгаан	1,939,802.00	2,049,237.00
210302	Түлш, халаалт	34,927,330.00	34,522,502.00
210303	Цэвэр, бохир ус	559,000.00	69,120.00
2104	Хангамж, бараа материалын зардал	17,890,632.07	21,143,746.00
210401	Бичиг хэрэг	779,740.00	1,313,300.00
210402	Тээвэр, шатахуун	13,406,400.00	16,021,400.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	673,200.00	1,361,800.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, арнутгал	1,091,900.00	2,077,105.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	00.00	275,141.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	1,939,392.07	95,000.00
2105	Нормативт зардал	22,462,570.00	25,622,919.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	15,885,049.00	19,061,139.00
210502	Хоол, хүнс	5,190,531.00	5,107,780.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,386,990.00	1,454,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,659,000.00	4,776,907.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	59,000.00	271,907.00
210602	Тавилга	00.00	1,660,000.00
210604	Урсгал засвар	2,600,000.00	2,845,000.00
2107	Томилолт, зочны зардал	1,112,000.00	1,015,000.00
210702	Дотоод албан томилолт	1,112,000.00	1,015,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	148,450.00	478,100.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	00.00	89,100.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	00.00	389,000.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	148,450.00	00.00

Заг сумын Эрүүл мэндийн төв 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2109	Бараа үйлчилгээний бусад зардал	35,386,432.10	45,030,747.27
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,467,630.00	9,148,430.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	32,918,802.10	35,882,317.27
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	25,972,353.00	1,539,732.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	25,961,274.00	00.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	25,961,274.00	00.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	11,079.00	36,641.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	11,079.00	36,641.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	00.00	1,503,091.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	1,503,091.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	-22,684,364.17	9,031,312.26
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	4,146,424.73	14,726,997.47
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	4,146,424.73	14,726,997.47
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-4,146,424.73	-14,726,997.47
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	-26,830,788.90	-5,695,685.21

4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	311,691,674.00	371,440,580.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	311,691,674.00	371,440,580.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	285,730,400.00	317,419,300.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	23,357,442.00	89,100.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	23,357,442.00	89,100.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	00.00	39,975,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	00.00	39,975,000.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	2,603,832.00	13,957,180.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	00.00	13,957,180.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	311,691,674.00	371,440,580.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	311,691,674.00	371,440,580.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	285,719,321.00	369,900,848.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	180,669,867.00	227,197,523.00
210101	Үндсэн цалин	136,799,596.00	171,845,000.00
210102	Нэмэгдэл	31,023,849.00	43,168,738.00
210104	Урамшуулал	12,846,422.00	12,183,785.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	21,057,742.00	28,378,536.00

Заг сумын Эрүүл мэндийн төв 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210201	Тэтгэврийн даатгал	16,892,311.00	18,924,700.00
210202	Тэтгэмжийн даатгал	977,454.00	2,409,500.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	359,209.00	1,743,436.00
210204	Ажилгүйдлийн даатгал	110,508.00	481,900.00
210205	Эрүүл мэндийн даатгал	2,718,260.00	4,819,000.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	36,963,882.00	36,968,359.00
210301	Гэрэл, цахилгаан	1,939,802.00	2,049,237.00
210302	Түлш, халаалт	34,465,080.00	34,522,502.00
210303	Цэвэр, бохир ус	559,000.00	396,620.00
2104	Хангамж, бараа материалын зардал	16,054,500.00	21,050,200.00
210401	Бичиг хэрэг	549,500.00	1,199,100.00
210402	Тээвэр, шатахуун	13,406,400.00	16,400,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	673,200.00	1,804,800.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,425,400.00	1,646,300.00
2105	Нормативт зардал	21,548,850.00	27,987,700.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	15,550,000.00	19,396,240.00
210502	Хоол, хүнс	3,498,850.00	6,113,460.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,500,000.00	2,478,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,200,000.00	12,832,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,600,000.00	5,552,000.00
210602	Тавилга	00.00	4,310,000.00
210604	Урсгал засвар	2,600,000.00	2,970,000.00
2107	Томилолт, зочны зардал	1,112,000.00	1,015,000.00
210702	Дотоод албан томилолт	1,112,000.00	1,015,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	148,450.00	478,100.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	00.00	89,100.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	00.00	389,000.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	148,450.00	00.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3,964,030.00	13,993,430.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,964,030.00	13,993,430.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	25,972,353.00	1,539,732.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	25,961,274.00	00.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	23,357,442.00	00.00
213203	Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	2,603,832.00	00.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	11,079.00	36,641.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	11,079.00	36,641.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	00.00	1,503,091.00
213502	Засгийн газрын, Засаг даргын нөөц хөрөнгө	00.00	00.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	1,503,091.00
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	2,603,832.00	00.00

Заг сумын Эрүүл мэндийн төв 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	2,603,832.00	00.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00

4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
D01	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	190,149,470.50	579,519,896.06	138,643,342.61	00.00	908,312,709.17
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	190,149,470.50	579,519,896.06	138,643,342.61	00.00	908,312,709.17
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-5,695,685.21	00.00	-5,695,685.21
D09	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	190,149,470.50	579,519,896.06	132,947,657.40	00.00	902,617,023.96

4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Өмнөх оны		Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	285,730,400.00	285,719,321.00	378,558,200.00	369,811,748.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	285,730,400.00	285,719,321.00	378,558,200.00	369,811,748.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	285,730,400.00	285,719,321.00	378,558,200.00	369,811,748.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	179,671,400.00	180,669,867.00	228,501,200.00	227,197,523.00
210101	Үндсэн цалин	136,808,800.00	136,799,596.00	171,845,000.00	171,845,000.00
210102	Нэмэгдэл	29,947,600.00	31,023,849.00	43,324,900.00	43,168,738.00
210104	Урамшуулал	12,915,000.00	12,846,422.00	13,331,300.00	12,183,785.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	21,715,300.00	21,057,742.00	28,562,700.00	28,378,536.00
210201	Тэтгэврийн даатгал	21,715,300.00	16,892,311.00	18,924,700.00	18,924,700.00
210202	Тэтгэмжийн даатгал	00.00	977,454.00	2,409,500.00	2,409,500.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	00.00	359,209.00	1,927,600.00	1,743,436.00
210204	Ажилгүйдлийн даатгал	00.00	110,508.00	481,900.00	481,900.00
210205	Эрүүл мэндийн даатгал	00.00	2,718,260.00	4,819,000.00	4,819,000.00

Заг сумын Эрүүл мэндийн төв 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	37,264,500.00	36,963,882.00	36,975,000.00	36,968,359.00
210301	Гэрэл, цахилгаан	2,399,400.00	1,939,802.00	2,052,200.00	2,049,237.00
210302	Түлш, халаалт	34,465,100.00	34,465,080.00	34,522,800.00	34,522,502.00
210303	Цэвэр, бохир ус	400,000.00	559,000.00	400,000.00	396,620.00
2104	Хангамж, бараа материалын зардал	16,068,600.00	16,054,500.00	24,489,700.00	21,050,200.00
210401	Бичиг хэрэг	550,000.00	549,500.00	1,200,000.00	1,199,100.00
210402	Тээвэр, шатахуун	13,406,400.00	13,406,400.00	19,273,700.00	16,400,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	712,800.00	673,200.00	2,016,000.00	1,804,800.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,399,400.00	1,425,400.00	2,000,000.00	1,646,300.00
2105	Нормативт зардал	21,560,000.00	21,548,850.00	30,327,000.00	27,987,700.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	15,550,000.00	15,555,000.00	20,917,000.00	19,396,240.00
210502	Хоол, хүнс	3,500,000.00	3,498,850.00	6,900,000.00	6,113,460.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,510,000.00	2,500,000.00	2,510,000.00	2,478,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,200,000.00	4,200,000.00	12,985,000.00	12,832,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,600,000.00	1,600,000.00	5,585,000.00	5,552,000.00
210602	Тавилга	00.00	00.00	4,400,000.00	4,310,000.00
210604	Урсгал засвар	2,600,000.00	2,600,000.00	3,000,000.00	2,970,000.00
2107	Томилолт, зочны зардал	1,112,000.00	1,112,000.00	2,320,000.00	1,015,000.00
210702	Дотоод албан томилолт	1,112,000.00	1,112,000.00	2,320,000.00	1,015,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	00.00	00.00	400,000.00	389,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	00.00	00.00	400,000.00	389,000.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	148,500.00	148,450.00	00.00	00.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3990100.00	3964030.00	13997600.00	13993430.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,990,100.00	3,964,030.00	13,997,600.00	13,993,430.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	285,730,400.00	285,719,321.00	378,558,200.00	369,811,748.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	285,730,400.00	285,719,321.00	317,419,300.00	315,916,209.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	00.00	00.00	317,419,300.00	315,916,209.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	00.00	00.00	39,975,000.00	39,938,359.00
132001	Орон нутгийн төсвөөс	00.00	00.00	39,975,000.00	39,938,359.00
1340	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	00.00	00.00	21,163,900.00	13,957,180.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	00.00	00.00	21,163,900.00	13,957,180.00
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	01.00	01.00	01.00	01.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	22.00	22.00	23.00	23.00
620001	Удирдах ажилтан	01.00	01.00	01.00	01.00
620002	Гүйцэтгэх ажилтан	16.00	16.00	17.00	17.00
620003	Үйлчлэх ажилтан	05.00	05.00	05.00	05.00

Заг сумын Эрүүл мэндийн төв 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

64	ЭМЧЛҮҮЛЭГСЭДИЙН ТОО	00.00	4203.00	4346.00	4346.00
640001	Улсын эмнэлгээр хэвтэн эмчлүүлэгсдийн тоо	00.00	292.00	333.00	333.00
640002	Улсын эмнэлгийн амбулатороор эмчлүүлэгсдийн тоо	00.00	3911.00	4013.00	4013.00
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	22.00	22.00	23.00	23.00
650008	Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮЭМ)	17.00	17.00	18.00	17.00
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	05.00	05.00	05.00	05.00

4.6 Аудит хийгдсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	3,357,442	89,100
21	УРСГАЛ ЗАРДАЛ	23,357,442	89,100
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	23,357,442	89,100
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	23,357,442	89,100
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		89,100
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	23,357,442	89,100
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	23,357,442	89,100
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	23,357,442	89,100

АУДИТЫН ТАЙЛАНГ

БЭЛТГЭСЭН:

АУДИТОР:

Г.ГАНЧИМЭГ 2020.02.13

АНХАН ШАТАНД ХЯНАСАН:

АУДИТЫН МЕНЕЖЕР:

А.ЦЭЭНЯМ 2020.02.13

ХОЁР ДАХЬ ШАТАНД ХЯНАСАН:

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:

Б.МӨНХБАТ 2020.02.13

